



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025ны 12 сарын 04 өдөр

Дугаар А/751

Булган сум

“Хүний папиллома вирусийн халдварын эсрэг  
вакцинжуулалтыг идэвхжүүлэхэд хэвлэл мэдээлэл,  
олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх нь”  
сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.6, Дархлаажуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын хамтарсан 2024 оны А/484, А/231 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцинжуулалтыг идэвхжүүлэхэд хэвлэл мэдээлэл, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх нь” сургалтын удирдамжийг 1 дүгээр, сургалтын хөтөлбөрийг 2 дугаар, сургалтын төсвийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Сургалтыг үр дүнтэй зохион байгуулан, дархлаажуулалтын ач холбогдол, вакцины талаарх үнэн зөв мэдээллийг түгээхэд нийтийн эрүүл мэндийн ажилтан, хэвлэл мэдээллийн ажилтан нарт зориулсан гарын авлагыг бэлтгэн хэвлүүлж, Эрүүл мэндийн байгууллагуудад болон олон нийттэй харилцдаг хэвлэл мэдээллийн ажилтан нарт хүргүүлэн ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга (П.Оюунцэцэг)-д даалгасугай.

3.Дээрх сургалтад зарцуулагдах 15,000,000 (арван таван сая) төгрөгийг Аймгийн Засаг даргын тамгын газрын нэмэлт дансанд шилжигдсэн Нэгдсэн Үүндэстний Байгууллагын Хүүхдийн сангийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025 оны  
12 дугаар сарын 06-ны ний өдрийн  
А/751 дүгээр захирамжийн 1 дүгээр хавсралт

**“ХҮНИЙ ПАПИЛЛОМА ВИРУСИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИНЖУУЛАЛТЫГ  
ИДЭВХЖҮҮЛЭХЭД ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ  
НЭМЭГДҮҮЛЭХ НЬ” СУРГАЛТЫН УДИРДАМЖ**

**Сэдэв:**Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцинжуулалтыг идэвхжүүлэхэд хэвлэл мэдээлэл, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх нь

**Үндэслэл:**Сүүлийн жилүүдэд хорт хавдрын өвчлөл, нас баралтын түвшин жилээс жилд өсөх хандлагатай байгаа нь хүн амын эрүүл мэндийн боловсрол, мэдээлэл түгээх тогтолцоог сайжруулах шаардлагыг бий болгож байна. Умайн хүзүүний хорт хавдрын гол шалтгаан болох хүний папиллома вирусийн (ХПВ) халдварын эсрэг вакцинжуулалтыг эрчимжүүлэх, олон нийтийн хэвлэл мэдээлэл, ойлголтыг нэмэгдүүлэх нь чухал ач холбогдолтой юм.

**Зорилго:**Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын нийгмийн эрүүл мэндийн ажилтан, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажилтан, сэтгүүлчдийг эрүүл мэндийн мэдээлэл түгээх арга зүйгээр хангах, вакцинжуулалтын талаарх зөв ойлголт, мэдээллийг олон нийтэд түгээх чадварыг дээшлүүлэх.

**Зорилтууд:**

- 1.ХПВ-ийн халдвар, вакцинжуулалтын ач холбогдлын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх
- 2.Эрүүл мэндийн сэдвийг мэргэжлийн, нийгмийн сэтгэлзүйд нийцүүлэн хүргэх арга зүйд сургах
- 3.Хэвлэл мэдээллийн ажилтнуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх
- 4.Олон нийтэд чиглэсэн мэдээллийн нөлөөллийг нэмэгдүүлэх

**Хамрах хүрээ:**Орон нутгийн Эрүүл мэндийн байгууллагын нийгмийн эрүүл мэндийн ажилтнууд, хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах ажилтнууд, орон нутгийн сэтгүүлчид

**Сургалтын хэлбэр:** Танхимын сургалт, хэлэлцүүлэг, дадлага

**Хаана:**Орхон аймгийн Эрүүл мэндийн газрын хурлын зааланд.

**Хэзээ:**2025 оны 12 дугаар сарын 06-ны өдөр

**Хүлээгдэж буй үр дүн:**Сургалтад оролцогчид эрүүл мэндийн мэдээллийг мэргэжлийн түвшинд түгээх чадвартай болох, ХПВ-ийн эсрэг вакцинжуулалтын талаарх олон нийтийн ойлголт, хандлага сайжирна. Вакцинжуулалтын хамрагдалт нэмэгдэнэ

**Зохион байгуулагч:**Булган аймгийн Эрүүл мэндийн газар

**Хамтран ажиллах байгууллага:**Аймгийн Засаг даргын тамгын газар, хэвлэл мэдээллийн байгууллагууд

Аймгийн Засаг даргын 2025 оны  
12-дугаар сарын 04-ний өдрийн  
А/А51 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралт

**“ХҮНИЙ ПАПИЛЛОМА ВИРУСИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИНЖУУЛАЛТЫГ  
ИДЭВХЖҮҮЛЭХЭД ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ  
НЭМЭГДҮҮЛЭХ НЬ” СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

д/д	Сэдэв	Цаг	Үргэлжлэх хугацаа	Хариуцах мэргэжилтэн
1	2	3	4	5
1	Сургалтын бүртгэл, нээлт	09:00-09:20	20 минут	Зохион байгуулагч нар
2	Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагын өнөөгийн байдал	09:20-09:50	30 минут	Сайхан Монгол телевизийн захирал Б.Мөнхбаатар
3	Хүүхдийн эрүүл мэндэд ХПВ-ийн дархлаажуулалт	09:50-10:30	40 минут	НЭМХ-ийн дарга Д.Нарантуяа
<b>Цайны завсарлага 10:30-11:00</b>				
4	Эрүүл мэндийн сэтгүүл зүйн тухай-Эрүүл мэндийн мэдээлэл харилцаа	11:00-11:30	30 минут	Б.Ундрах МЭМСЦҮХ-г үүсгэн байгуулагч, эрүүл мэндийн сэтгүүл зүйн багш, докторант
5	Нийтийг хамарсан эрүүл мэндийн эрсдэл үүсэхэд хэвлэл мэдээллийнхэн хэрхэн ажиллах вэ-баримт, факт, шийдэл	11:30-12:05	30 минут	Ц.Чимэддондог МЭМСЦҮХ-ны зөвлөх, сургагч багш
6	Олон нийттэй харилцах, эрүүл мэндийн мэдээллийг хүртээмжтэй хэлбэрээр хүн амд хүргэх мэдлэг, ур чадвар	12:05-12:40	35 минут	А.Сарантуяа МЭМСЦҮХ-ны сургагч багш, НЭМ-ийн магистр
<b>Үдийн завсарлага 12:50-14:00 60 минут</b>				
7	Мэдээлэлд тохирсон мессеж асууж боловсруулах	14:05-14:40	35 минут	Ц.Чимэддондог МЭМСЦҮХ-ны зөвлөх, сургагч багш
8	(ХПВ) халдварын эсрэг вакцинжуулалтыг эрчимжүүлэх, олон нийтийн мэдээлэл, ойлголтыг нэмэгдүүлэх нь чухал ач холбогдол	14:50-16:25	35 минут	А.Сарантуяа МЭМСЦҮХ-ны сургагч багш, НЭМ-ийн магистр
9	Эрсдэлийн харилцаа холбоо, зарчим, мэдээллийн чанар	16:30-17:30	30 минут	Б.Ундрах МЭМСЦҮХ-г үүсгэн байгуулагч, эрүүл мэндийн сэтгүүл зүйн багш, докторант
10	Халдварт бус өвчний өнөөгийн байдал	17:30-18:00	30 минут	Ж.Гүндэгмаа Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтэн)
11	Интерактив арга -“Мэдлэгийн сорил”			Зохион байгуулагч нар

Аймгийн Засаг даргын 2025 оны  
12-дугаар сарын 04-ны/ний өдрийн  
K/asi дүгээр захирамжийн 3 дугаар хавсралт

**“ХҮНИЙ ПАПИЛЛОМА ВИРУСИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ВАКЦИНЖУУЛАЛТЫГ  
ИДЭВХЖҮҮЛЭХЭД ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ  
НЭМЭГДҮҮЛЭХ НЬ” СУРГАЛТЫН ТӨСӨВ**

д/д	Descriptions by Line Items Ажил гүйлгээний утга	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Үнэ (төгрөг)	Total/ Бүгд
1	2	3	4	5	6
1	Багш нарын ирэх, буцах зардал	х	3	200,000	600,000
2	Багш нарын ажлын хөлс	х	6	500,000	3,000,000
3	Багш нарын буудал	ш	4	180,000	720,000
4	Орон нутгаас оролцогчдын томилолт	ш	34	40,000	1,360,000
5	Орон нутгаас оролцогчдын унааны зардал	ш	34	30,000	1,020,000
6	Сургалт зохион байгуулах чиглүүлэгчийн зардал	ш	1	300,000	300,000
7	Сургалтын туслах ажилтны зардал	ш	1	100,000	100,000
8	Дэвтэр, бал	ш	50	19,000	950,000
9	Цайны зардал	ш	50	16,000	800,000
10	Хоолны зардал	ш	50	23,000	1,150,000
11	Эрүүл мэндийн мэдээ, мэдээлэл бэлтгэх 2 төрлийн гарын авлага (сэтгүүлч, эрүүл мэндийн нийгмийн ажилтан нарт)	ш	100	50,000	5,000,000
<b>Total amount/ Нийт дүн- 15,000,000</b>					

--o0o--